

# Тамд өнгөрүүлсэн 23 минут

Билл Вайс



Энэ түүхийг түүний номноос биш аудио CD-ээс авсан болно. Түүхийг дэлгэрэнгүй уншъя гэвэл түүний номыг худалдан авна уу. Энэ бол АНУ-ын Кансас мужийн Кансас хотод болсон “Америкийн төлөөх Кансас хот” гэсэн конвенцийн үеэрх бичлэг юм. Тамд очсон үйл явдал 1998 оны 11 сарын 23-нд болжээ.  
(Хөтлөгчийн танилцуулга)

Хэдэн сарын өмнө надтай хамтран ажилладаг [International House of Prayer](#) цуглааны Майк Бикл намайг тамын тухай номлохыг хүссэн юм. Энэ сэдвийг судалж байх явцад миний найз Стив Карпентер надад нэгэн бичлэгийг өгсөн юм. Тэр бичлэг дээр одоо та бүгдийн сонсох гэж байгаа Билл Вайс болон түүний эхнэр Аннете нарын түүх байсан. Энэ түүх миний ертөнцийг донсолгосон. Энэ зүйл миний гэр бүл, найз нөхөд, тэр ч байтугай танихгүй хүмүүстэй харьцах миний харилцааг үүрд өөрчилсөн. Та намайг хэтрүүлж байна гэж битгий бодоорой, би та нарын сэтгэлийг хөдөлгөх гэсэн юм биш. Энэ зүйл дэлхий дээрх үлдсэн амдралаа хэрхэн өнгөрөөх вэ гэсэн миний бодлыг өөрчилсөн. Бурхан өнөөдөр таныг ч бас өөрчлөөсэй гэж би залбирч байна. Би энэ түүхийн ач холбогдлыг хэтрүүлж байгаа юм биш. Билл бол Христэд итгэгч. Тэр 16 настайдаа Христийг хүлээн авсан бөгөөд Эзэнийг 32 жилийн турш мэдэж байгаа. Тэр 1976 онд Калефорнийн Коста Меса хот уруу нүүсэн бөгөөд тэнд Чак Смит пасторын удирдлага дор 10 жил үйлчилсэн. Билл эхнэртэйгээ адил үл хөдлөх хөрөнгийн зуучлагчаар ажилладаг. Сүүлийн 15 жилийн турш Билл цуглаанд үйлчилж байгаа бөгөөд Калефорнийн Оранж хотод Др. Гари Грийнволд пасторын удирдлага дор [Eagles Nest](#) цуглааны бүхий л үед удирдлагын багт ажиллаж ирсэн. [Eagles Nest](#) цуглааны пастор Раул түүнд хэдэн сарын өмнө “Билл, Бурхан сэргэлтийг хийх гэж байна. Тэр Кансасаас эхлэн бүх Америк даяар сэргэлтийг өгөх гэж байна. Тэр чамайг үүний тулд илгээх бөгөөд чи явах хэрэгтэй” гэж хэлжээ. Билл болон түүний эхнэр урьд өмнө хэзээ ч Кансас хотод ирж байгаагүй. Дараагийн өдөр нь би Билл уруу утасдаж “Та Кансас хотод ирэхгүй юм уу? Би таны бичлэгийг үзсэн. Энд ирэх хэрэгтэй байна” гэж хэлсэн. Тэд одоо энд Бурханы дуудлагаар ирсэн гэдэгт би итгэж байна.

Та бүгд одоо тамын тухай сонсох гэж байна, түүнээс ч илүүгээр Есүс Христтэй ойртон дотносож, хүн төрөлхтөнд зориулсан Түүний хайрын тухай сонсох гэж байна. Билл тамд очсон бөгөөд тэнд байхдаа ихэнх хүмүүстэй адил зүйлийг харж, хөндлөнгийн нүдээр ажиглан хараагүй юм. Харин тэр тэндээс зайлан гарах ямар ч аргагүйгээр тамын тарчлал зовлонг өөрийн биеэр хагас цаг орчим эдэлсэн. Билл эхнэртэйгээ хамт Есүс Христ, Бурханы ажил үйлчлэл, Ариун Сүнсний

удирдлагад өөрсдийнхөө амьдралыг бүрэн зориулсан хүмүүс юм. Танд тэр таалагдана гэдэгт найдаж байна. Билл, Аннете хоёрыг угтан хүлээн авна уу.

*(Билл Вайс ярьж байна)*

Өнөөдөр та бүхний дунд байгаадаа баяртай байна. Бидний амьдрал бол Бурханы ивээл юм. Халын хэлснээр бид үл хөдлөх хөрөнгийн зуучлагчаар ажилладаг, бид энэ ажлыг өөрсдийнхөө амьдралын төлөө хийгээгүй, мөнгөний төлөө ч хийгээгүй, зөвхөн Бурхан биднийг дэлхий уруу явж, хүмүүст зориулсан Түүний хайр болон өөрийнхөө бүтээлүүдийн нэгийг нь ч явуулахыг хүсдэггүй тэр газрын тухай хэлүүлэхийн тулд энэ ажлыг хийж байна. Тийм ч учраас бид өнөөдөр энд зогсож байна. Цаг хэмнэх үүднээс би өөрийнхөө гэрчлэлээс товчхон хуваалцахын тулд шууд яриандаа орьё.

Эхлээд би та бүгдийн санаанд орж ирж магадгүй хоёр зүйлийн тухай тодруулахыг хүсч байна. Эхний асуулт бол, би өөрөө өөрөөсөө асууж байсан, “Энэ зүйл зүүд биш гэдгийг чи яаж мэдэхийн бэ? Зүгээр л нэг хар дарсан зүүд байсан байвал яах вэ?” Үүн дээр хоёр зүйлийг хэлэхэд нэгдүгээрт, миний сүнс биенээсээ гарсан байсан. Намайг буцаж ирэхэд миний бие шалан дээр хэвтэж байсан. Би биенээсээ гарсан гэдгийг баттай мэддэг. Зарим Христчид “Христэд итгэгчид биеэ орхиж чадахгүй” гэдэг. Гэвч энэ бол худал, [2 Коринт 12:2](#) дээр Паул гурав дахь тэнгэр уруу очсон тухай “*бие дотроо юу, эсвэл биеийнхээ гадна уу гэдгийг нь би мэдэхгүй*” гэж хэлсэн байдаг. Хоёрдугаарт, 1-р ишлэлд энэ бол үзэгдэл байсан гэж хэлдэг. Тийм болохоор би үүнийг үзэгдэл гэдэгт итгэдэг.

[Иов 7:14](#)-т “*Та зүүдүүдээр намайг айлгаж, үзэгдлүүдээр намайг сүрдүүлдэг*” гэж хэлсэн. Тэгэхээр энэ бол үзэгдлээр дамжуулан гарцаагүй Эзэний надад хийсэн зүйл бөгөөд аймшигтай зүйл байсан. Тэндээс эргэж ирснийхээ дараа би энгийн хүн шиг болж тайвшрах гэж нэг жил болсон. Надад тохиолдсон аймшигтай зүйлээс болж би маш их сэтгэлээр унаж, стресст орсон байсан. Энэ нь бусдад хэрхэн гэрчлэх талаарх миний бүх л үзэл бодлыг өөрчилж, Бурхан биднийг юунаас аварсныг үнэлж үзэхэд нөлөөлсөн.

Би зочны өрөөнд шалан дээр хэвтэж байхдаа юу тохиолдсоныг санадаггүй учраас эхнэрийгээ энэ талаар ярьж өгөөч гэж гуйсан юм. Энэ талаар түүнийг товчхон ярихыг хүсч байна. Баярлалаа.

*(Биллийн эхнэр Аннете ярьж байна)*

Намайг сэрэхэд шөнийн 3:23 цаг болж байсан. Би сэрээд Биллийг хажуудаа байхгүй байгааг мэдээд цагаа харсан учраас цаг хэд болж байсныг сайн санаж байна. Би зочны өрөөнөөс хүн хашгирахыг сонссон. Доошоо шатаар буун өрөө уруу очсон. Нөхрийгөө хэзээ ч тийм байдалтай байхыг урьд нь харж байгаагүй. Биллийг мэддэг хүн бол тэр төрөлхийн хуучинсаг үзэлтэй, маш тайван, юманд мэргэжлийн үүднээс ханддаг гэдгийг мэднэ. Бурханы цаг л биш юм бол тэр хэзээ ч сэтгэл хөдөлж байхыг би хараагүй. Тэр зочны өрөөний шалан дээр толгойгоо бөхийлгөн байдгаараа хавчийн сууж байсан. Би юу хийхээ мэдэхгүй түүнийг зүрхний шигдээс болсон юм болов уу гэж бодсон. Би залбирч эхэлсэн, тэр “*Эзэн намайг тамд аваачсан. Миний толгойноос энэ зүйлийг зайлуул гэж Эзэнээс гуй. Би үхэхнээ, тэсэхгүйнээ*” гээд уйлаад байсан. Тэгээд би түүний төлөө залбирч эхэлсэн, 10, 20 минутын дараагаар тэр тайвширч эхэлсэн. Тэр маш стресс, дарамтад орсон байсан, яг л Вьетнамд дайтаж байсан цэрэг шиг, эсвэл ямар нэгэн аймшигтай

машины ослын тухай эргэн санаж байгаа юм шиг, хий юм харж байгаа хүн шиг байсан. Энэ бол зүгээр л нэг хар дарж зүүдлээд сэрэхтэй адилгүй зүйл байсан. Тийм болохоор би энэ тухай гэрчлэн ярихыг хүссэн.

*(Билл Вайс ярьж байна)*

Бурхан надад сайн эхнэр өгсөнд би үнэхээр их талархдаг. Бид гэрлээд 4 жил болсон бөгөөд түүнийг би 6 жил мэднэ, энэ 6 жил миний амьдралын хамгийн сайхан жилүүд байсан, Бурханд талархъя.

Би тамаас эргэж ирснийхээ дараа Библид там уруу очсон хүн байдгийн болов уу гэж хайж эхэлсэн. Би Чак Мисслерийг их сонсдог. Тэр Америк даяар алдартай Библийн багш, эрдэмтэн бөгөөд Иона тамд очсон гэж хэлж байсан. [Иона 2:2](#)-т *“Үхэгсдийн орны гүнээс тусламж гуйн хаширахад...”* гэж хэлдэг. Бас [Иона 2:6](#)-д *“... дэлхий өөрийн хаалтнуудтайгаа миний эргэн тойронд мөнхөд байлаа. Гэвч, миний Бурхан ЭЗЭН, Та миний амийг нүхнээс гаргасан”* гэдэг. Тэгэхлээр Библид тамд очоод ирсэн хүн бол Иона байсан.

Би Калвари Чапел сүмд бага байхаасаа өссөн болохоор хэрэв танд ямар нэгэн сүнслэг аялал тохиолдвол тэр нь Бурханы үгэнд хэлэгдсэн байх ёстой гэж заадаг байсан. Тийм болохоор би хэрэв надад тохиолдсон зүйл үнэн юм бол Бурханы үгэнд бас хэлэгдсэн байх ёстой гэдгийг мэдэж байсан учраас Библиэс хайж эхэлсэн. Миний тамд харж, мэдэрч, сонсож байсан бүхэн, тамд болдог бүх үйл явдал Библид байсан бөгөөд би 400 гаруй Библийн ишлэл олсон. Түүнчлэн тамын зарим нэг хэсгийг үзсэн 14 хүн байдгийг мэдсэн. Тэдний олонх нь үхлийн дараах амьдралыг үзсэн хүмүүс байсан бөгөөд эмнэлэгт үхээд эргэж амилсан хүмүүс байсан.

Шууд яриандаа орьё: Эхнэр бид хоёр пасторуудтай үргэлж хийдэг Ням гаригийн оройн залбирлын цуглаанаас ирээд бусад өдрүүдийнхтэй адил унтахаар хэвтсэн. Шөнийн 3 цагийн орчимд би там уруу явсан. Тэндээс эргэн иртлээ би тийшээ яаж очсоноо мэддэггүй. Эзэн надад энэ тухай сүүлд тайлбарлаж өгсөн. Би шоронгийн нэг өрөөнд, яг л жирийн нэг шоронтой адил хаалгандаа сараалжин төмөртэй, хананууд нь чулуун ханатай өрөөнд байж байсан. Би хаана байгаагүй мэдэхгүй байв. Миний мэдэж байсан зүйл гэвэл тэнд маш халуун, аймшигтай халуун байсан. Би тийм их халуунд амьд байгаадаа итгэж чадахгүй байсан. Би тэр халуун байдалтай нэгдсэн мэт байсан ч амьд гэдгээ мэдэрч байсан. Өрөөнд жижигхэн гэрэл гарсан, миний байгаа орчныг сайн харуулахын тулд Эзэний оршихуй тэнд байсан гэж би боддог, дараа нь нэг минут хиртэй харанхуй болсон.

[Исаиа 24:22](#)-т *“Тэд гяндан дахь хоригдлууд мэт хамтдаа бөөгнөрөөд шоронд хоригдоно”* гэж хэлсэн. [Сургаалт үгс 7:27](#)-д *“Түүний гэр Үхэгсдийн оронд хүрдэг агаад үхлийн танхимууд уруу уруудах зам аж”*. “Танхимууд” гэдэг нь өрөө гэсэн утгатай. Тамын зарим хэсгүүдэд өрөө, танхим, галтай нүхнүүд, хэсэг газрыг бүрхсэн галтай хэсгүүд байдаг. Би эдгээрээс өрөөнд нь байсан.

Бас [Иона 2:6](#)-д *“... дэлхий өөрийн хаалтнуудтайгаа миний эргэн тойронд мөнхөд байлаа. Иов 17:16-д *“Тэр нь надтай хамт Үхэгсдийн орон уруу буух болов уу?”* \орч. Библийн англи орчуулган дээр “үхэгсдийн орны хаалтнууд уруу буух болов уу” гэж байдаг\ Тэгэхлээр миний тамд харсан бүх зүйлс Библид бичигдсэн байсан. [Исаиа 14:19](#)-т чулуун хананы тухай хэлсэн байдаг.*

Би өөрийгөө нэгэн өрөөнд байгаа мэдсэн бөгөөд 4 амьтантай хамт байгаагаа мэдсэн. Тухайн үед би тэдгээр амьтдыг муу сүнснүүд гэдгийг нь мэдээгүй, яагаад гэвэл би тэнд аврагдаагүй хүн шиг очсон байсан. Бурхан миний санаанаас намайг Христэд итгэгч гэдгийг минь арилгасан байсан. Учрыг нь би ойлгоогүй боловч Есүс Эзэн надад сүүлд тайлбарлаж өгсөн. Эдгээр амьтдыг би муу сүнснүүд гэж мэдээгүй, тэд маш том биетэй байсан. Тэд ойролцоогоор 3.5-4 метр өндөр, та нар видеоноос хараарай. Нэгэн хүний гэрчлэлийг сонсож байхад тэр бас надтай адил тэдгээр муу ёрын сүнснүүдийг харсан байсан. Энэ бол Кеннет Хаганы гэрчлэл юм. Та бүхэн ямар дүр төрхтэй харагдаж байсныг нь бичлэгээс үзэх болно. Энэ бичлэг нь нэг хүнийг тамын нүх уруу шидэж байгаа сайн дүрслэлтэй зураг болсон байдаг.

Тэр амьтад хайрстай байсан. Нэг нь бүх бие дээгүүрээ хайрстай, том соёонуудтай, урт савартай, хүнхгэр нүдтэй байсан. Тэд аварга том биетэй байсан. Бас нэг нь нөгөө амьтнаасаа өөр хэлбэртэй, нэг урт гаран дээрээ маш хурц сэрвээнүүдтэй, хөл нь урт богино харагдаж байсан. Тэдгээр амьтдын бүх зүйл нь гажигтай, мурий, буруу харьцаатай, нэг гар нь нөгөөхөөсөө урт эсвэл богино, ер нь нэг л сонин аймшигтай, маш аймшигтай амьтад харагдаж байсан.

Тэд Бурханыг хараан зүхэж байсан. Цаг үргэлж л хараагаад байсан. Би *“Яагаад энэ амьтад Бурханыг хараагаад байгаа юм бол? Бурханыг яагаад тэгтлээ их үзэн ядаад байгаа юм бол?”* гэж бодсон. Дараа нь тэд над уруу эргэж хараад Бурханыг үзэн ядаж байсан тэр үзэн ядалтаараа намайг харж эхэлсэн. Би дотроо *“Тэд яагаад намайг үзэн ядаад байгаа юм бол? Би тэдэнд муу юм юу ч хийгээгүй шүү дээ”* гэж бодсон. Гэвч би урьд өмнө амьдралдаа мэдэрч байгаагүй маш их үзэн ядалтыг, хүний хүч чадлаас давсан үзэн ядалтыг мэдэрсэн. Тэд гарцаагүй намайг үзэн ядаж байсан бөгөөд намайг тамлан зовоохын тулд томилогдсон гэдгийг мэдсэн.

Би яаж мэдэж байгаагаа мэдэхгүй зарим зүйлүүд тэнд болж байсан. Тамд таны бүх мэдрэхүй маш тод, бие махбодийн мэдрэхүйгээс ч илүү тод байдаг. Би дэлхий дээр байснаасаа илүү хол ойр, цаг хугацаа, өөр олон зүйлүүдийг мэдэрч байсан. Би энд үүрд тамлагдан зовохоор эдгээр амьтдын гарт орсон гэдгээ мэдсэн.

Би өрөөний шалан дээр ямар ч хүч чадалгүй хэвтэж байв. *“Яагаад би хөдөлж чадахгүй байгаа юм бол? Надад юу болоод байгаа юм бол?”* гэж бодсон. Надад ямар ч хүч чадал байхгүй, шалан дээр ямар ч найдваргүй хэвтэж байгаагаа мэдсэн. Нэг муу сүнс намайг шүүрэн авч, хана уруу шил хагалахтай адил шидсэн. Тэр намайг шил шиг хөнгөхөөн аваад шидчихсэн. Би яг л тийм хөнгөн, ямар ч хүч чадалгүй болчихсон байсан. Намайг хана уруу авч шидэхэд миний бүх яс хугарах шиг болж, өвдөж байгаагаа мэдэрсэн. Тэнд шалан дээр хэвтээд өршөөл эрэн уйлсан боловч тэдгээр амьтад ямар ч өрөвдөх сэтгэлгүй байхгүй гэдгийг мэдсэн.

Picture of demons ???????????????????????????

Бас нэг нь намайг шүүрэн авч, хурц савартай нэгэн нь миний биеийг шууд урж эхэлсэн. Тэр зүгээр л урж, тасдаж, хагалж байсан, Бурханы гайхамшигтайгаар бүтээсэн энэ биеийг ямар ч өршөөлгүйгээр урж тасдаж байсан. Намайг асар их үзэн ядаж байгааг би мэдэрсэн. Би *“Яагаад би амьд байгаад байгаа юм бол? Яагаад би энэ бүхний эцэст амьд үлдэж чадаад байгаа юм бол? Би яагаад үхэхгүй байгаа юм бол?”* гэж бодсон. Миний бие яг л лент шиг тэнд дүүжлээстэй байсан. Надаас ямар ч цус гарахгүй байсан, яагаад гэвэл цусанд амь байдаг, тамд ямар ч амь цус

байхгүй байсан. Тамд бас ус байхгүй байсан.

In [Исаиа 14:9-10](#)–т хэлэхдээ:

*Доороос Үхэгсдийн орон ч чамайг ирэх үед чинь уулзах гэж хөөрнө. Тэр чамд зориулан үхэгсдийн сүнснүүдийг болон газрын бүх л дээдсийг сэрээн, үндэстнүүдийн бүх хаадыг сэнтийнүүдээс нь босгоно. Тэд бүгд чамд хариулан “Чи ч бидэн шиг сул дорой болсон”*

[Дуулал 88:4](#)

*Би доошоо нүх уруу буугчдын дунд тоологдсон.  
Би хүч чадалгүй хүнтэй адил,*

Муу сүнсэнд хүч чадал байдаг гэж бид мэднэ, Бичээст булшин дундуур гүйж байсан нэгэн муу сүнсэтэй хүний тухай өгүүлсэн байдаг:

[Марк 5:1-4](#)

*Тэд нуурын нөгөө эрэг болох Герас нутагт иржээ. Түүнийг завинаас буухад тэр даруй бузар сүнсэтэй хүн булнаас гарч Есүстэй учрав. Тэр хүний орон байр нь булшнуудын дунд байв. Хэн ч түүнийг хүлж чадсангүй, бүр гинжээр ч хүлж чадсангүй. Учир нь тэр олон удаа гавтай, гинжтэй байсан ч гинжээ тастаж, гаваа хэдэн хэсэг болгон эвдчихдэг байв. Түүнийг номхтгоход хэний ч хүч хүрсэнгүй.*

Хүмүүс түүнийг хүлж чадахгүй байсан, тэр өөрийг нь хүлсэн гинжнүүдийг тас татаж хаяж байсан. Энэ бол зөвхөн муу сүнсний хүч чадлаар хийгдэж чадах зүйл. Эдгээр амьтад хүнээс 1000 дахин хүч чадалтай гэдгийг би ойлгосон. Би тэнд хүний хүч чадалтайгаа байсан ч тэдгээр амьтдыг дийлж чадаагүй. Тиймээс өрөвдөх сэтгэлгүй тэднээс би өршөөл эрсээр байсан. Муу ёрын сүнснүүд тамд таны амьдралыг удирддаг.

Эдгээр амьтдын үнэр, тамын үнэр танар үнэхээр аймшигтай. Би та нарт дүрслэн хэлж чадахгүй байна. Тэнд шатаж буй махны үнэр, хүхэр ханхалж байсан. Эдгээр амьтдын үнэр яг л муу усны хоолойны үнэр шиг, муудсан мах, өндөг, гашилсан сүүний үнэр шиг, таны бодол төсөөлөлд төрөх бүхий л муухай үнэр тэндээс гарч байсан. Та тийм үнэрийг хамраараа үнэрлэн амьсгалж байна гээд бод доо. Та зүгээр л үнэрлээд л байж байна. Энэ үнэр таны биед маш хортой бөгөөд таныг хөнөөж ч чадна, хэрэв та тэнд бие махбодиороо очвол үхэх болно. “Би яаж энэ үнэрийг тэвчиж байгаа юм бол? Ямар муухай үнэр вэ?” гэж бодсон. Гэвч та тэнд үхэхгүй, амьд байсаар л байна.

Бурханы эсрэг хараалын тухай [Езекел 22-26](#)–д байдаг \орч. англи орчуулган дээрээ жигшигдсэн биш хараагдсан гэсэн утгатай байдаг. “*Би тэдний дунд жигшигдсэн юм*”

*Түүний тахилч нар Миний хуулийг хэрцгийгээр зөрчиж, Миний ариун юмсыг бузарлав:*



*Тэд ариун болон жигшүүрийг хооронд нь эс ялган, бузар болон цэврийн ялгааг заасангүй. Тэд Миний амралтын өдрөөс нүдээ нууж, Би тэдний дунд жигшигдсэн юм.*

Энэ бол бүдүүлэг, хараалын, доромжилсон, бузар үгс юм.

Намайг тамлаж байсан тамлалтын тухай [Дэд хууль 32:22-24-т](#) байдаг.

*Миний хилэнгийн гал дүрэлзэн Үхэгсдийн орны гүнд хүртэл шатааж, газрыг ургацтай нь залгин, уулсын суурьд ч гал тавина. Би тэдэн дээр гай гамшгийг овоолж, сумаа тэдэн дээр буулгана. Тэд өлсгөлөнгөөр үрэгдэн, гал шиг халуун, гашуун сүйрлээр сөнөх болно. Би бас тэдэн уруу араатны шүд, тоос шороонд мөлхөгчдийн хорыг илгээнэ.*

Тэгэхлээр тэнд таныг араатны шүд хазах болно.

[2 Самуел 22:6](#) :

*Үхэгсдийн орны уяа намайг хэрж, үхлийн тор над уруу чиглэв.*

[Мика 3:2](#) дээр Израильчуудыг үзэн яддаг Филистчүүдийн тухай нэгэн сонирхолтой ишлэл байдаг:

*Та нар сайныг үзэн ядаж, мууг хайрлан, тэдний арьсыг нь хуулж, яснаас нь махыг нь салгадаг*

Энэ бол филистчүүд иудей хүмүүст хэрхэн хандаж байсныг харуулдаг. Энэ бол ердийн байдлаар хэлсэн зүйл юм. Гэвч тэд энэ санааг хаанаас авсан бэ? Тамаас энэ санаа ирсэн. Энэ бол муу сүнснүүдийн хийдэг ажил юм. Тэгвэл өршөөлийн тухайд? Зөвхөн тэнгэрийн улсад өршөөл байдаг. Өршөөл Бурханаас ирдэг бөгөөд муу сүнс ямар ч өршөөлийг мэдэхгүй, тэд энэ талаар юу ч мэдэхгүй. [Дуулал 36:5](#)

*ЭЗЭН, Таны энэрэл тэнгэрт бий! Таны итгэмж огторгуйд ч хүрнэ.*

Энэ бол там биш гэдэг нь тодорхой. [Дуулал 74:20](#) хэлэхдээ:

*Гэрээг эргэн хараач. Учир нь газар нутгийг харанхуй газрууд хүчирхийллийн орших сууцаар дүүрсэн.*

Энэ бол тэсэн гарч чадашгүй зэрлэг, эмгэнэлтэй, аймшигтай газар. Гэвч та энэ бүгдийг туулан гарахаас аргагүй.

Бурхан өөрийн хамгийн дээд бүтээлүүдийнхээ дотор бас хамгийн дорд амьтдыг бүтээсэн. Хүмүүс бид энэ амьдралдаа бусдаас дээр гарахын тулд өөрийгөө хөгжүүлж, суралцдаг. Гэвч тамд таны амьдралыг муу сүнснүүд удирддаг. Эдгээр амьтдын оюун ухааны төвшин 0 бөгөөд ямар ч хайхрамж анхаарал байдаггүй. Тэдний мэдэх ганц зүйл бол Бурханыг үзэн ядах, таныг үзэн ядаж, тамлах. Тэд таны амьдралыг удирдах бөгөөд та юу ч хийж чадахгүй.

Бичээст ямар доромжлолыг туулах тухай бичсэн байдаг. Тамд миний амьдралыг удирдаж байсан бөгөөд би зогсоож чадахгүй байсан! [Исаиа 5:14-15](#)

*Миний ард түмэнд мэдлэг дутсанаас болж тэд цөлөгдөн, тэдний хүндэт хүмүүс нь өлсөж, олон түмэн нь цангаж зовно. Тиймээс Үхэгсдийн орон хоолойгоо өргөсгөн, амаа хязгааргүй ангайлгав. Иерусалимын сүр жавхлан, олон түмэн, түүний дуу чимээ, хөгжил, баясал тийшээ бууна. Хүн номхтгогдож, хүн басамжлагдана. Бардам хүний нүд ч басамжлагдана.*

### [Исаиа 57:9-16](#)

*Чи хаан уруу тостой очиж, үнэртнээ нэмэгдүүлсэн. Чи элчингүүдээ алс хол газар илгээн, Үхэгсдийн орон уруу буулгасан. Замын уртад чи ядарсан боловч, "Найдлага тасарлаа" гэж хэлээгүй. Чи хүч тэнхээгээ сэргээн олсон учраас шантраагүй. "Намайг зүрхэндээ хадгалж дурсалгүй, худал хэлж байхдаа чи хэнээс эмээж зовнисон бэ? Би удаан хутацааны турши чимээгүй байсан учраас чи Надаас эмээхгүй юу? Би чиний зөв шударгыг болоод үйлсийг чинь тунхаглана. Гэвч тэдгээр нь чамд ашиггүй. Орилж хашхирахад чинь чамайг шүтээний цутлуулга чинь авраг! Харин салхи тэднийг чинь бүгдийг нь хийсгэж, амьсгал ч тэднийг авна. Харин Надад хоргодогч нь газрыг өмчлөн, Миний ариун уулыг эзэмшинэ". "Босгогтун, босгогтун. Зам бэлтгээгтүн. Миний ард түмний замаас саадыг зайлуул" гэж хэлэгдэх болно. Мөнх амьдрагч Түүний нэр нь Ариун бөгөөд өндөрт өргөмжлөгдсөн Нэгэн үүнийг айлдав. "Би дорд нэгний сүнсийг сэргээж, гэмшсэн нэгний зүрхийг амьдруулахын тулд гэмшсэн болон даруу сүнстэй хүмүүстэй хамт өндөр, ариун газарт оршдог. Би мөнхөд буруутгахгүй, үргэлж ууртай байхгүй. Учир нь сүнс болон Миний бүтээсэн амьсгал нь Миний өмнө сул дорой болно.*

### [Езекиел 32:24](#)

*Елам тэнд байгаа бөгөөд түүний хамаг олон түмэн нь түүний булшны эргэн тойронд байна. Тэд бүгд алагдагсад бөгөөд илдэнд унасан, хөвч хөндүүлээгүй хүмүүс юм. Тэд газрын хамгийн доод хэсэгт очсон. Амьдын газарт тэд айдсыг төрүүлэгчид юм. Тэд нүхэнд орогсодтой хамт өөрсдийн ичгүүрийг үүрсэн.*

Тэнд ийм байдал үргэлж байна. Эдгээр амьтад таны амьдралыг удирдах бөгөөд тэдэнд таныг өрөвдөх ямар ч сэтгэл байхгүй.

*(Там дахь хашгираан, харанхуй байдал)*

Би өрөөндөө хэвтэж байсан, маш харанхуй пад харанхуй болсон. Би урьд өмнө нь тийм харанхуй байдлыг харж байгаагүй. Би агуйн хамгийн доод хэсэгт, Аризонийн төмрийн уурхайн хамгийн доод хэсэгт байгаа мэт л санагдаж байсан. Энэ нь хүний төсөөллөөс даван гарсан зүйл байсан. Би мөлхөх гэж оролдсон, тэд намайг мөлхөхийг зөвшөөрсөн юм шиг байсан. Би хаалга хаана байсныг санаж байсан учраас тийш мөлхөж, өрөөний хаалгаар гарсан. Би нэг зүг уруу харсан, бүх юм

харанхуй, зөвхөн олон тэрбум хүмүүсийн орилох, хашгирах дуу чимээг сонсч байсан. Хэрэв та хэн нэгний хашгирч байгааг сонсвол чихэнд маш тээртэй сонсогддог. Тэгвэл олон тэрбум хүмүүс тэгж хашгирахыг сонсвол таны оюун ухаан хэрхэн хүлээж авах вэ. Та тэсч чадахгүй биз дээ. Аймшигтай чанга дуу таны биеийг нэвтлэн гарахад та өөрийн эрхгүй чихээ таглана. Гэвч энэ дуу чимээнээс та хаашаа ч зугтан гарч чадахгүй.

Түүнчлэн таныг нөмрөх айдас тэсвэрлэшгүй. Бүх зүйл аймшгаар дүүрэн байсан. Энэ газар Бурханы оршихуй гэж байхгүй учраас танд энэ газрын айдас, тарчлал зовлон, харанхуйг туулан гарахаас арга байхгүй. Танд юу ч харагдахгүй. Таны өмнөөс юу ирж байгааг та мэдэхгүй. Бичээст энэ харанхуй байдлын тухай бичсэн байдаг. [Дуулал 88:6](#)

*Та намайг хамгийн гүнзгий нүхэнд, харанхуй газруудад, гүнд тавьсан.*

### [Илчлэлт 16:10](#)

*Тав дахь нь аягатайгаа араатны сэнтий дээр асгав. Түүний хаанчлал харанхуй болж, тэд өвдсөндөө хэлээ хазалж,*

### [Иуда 1:13](#)

*... өөрсдийнхөө шившгийг далайн хөөс шиг хөөсрүүлэн хаялах тэнгисийн догшин давалгаа, хэрэн тэнүүчлэгч одод мөн. Түнэр харанхуй нь тэдний төлөө уурд хадгалагдсан юм.*

[Египетээс гарсан нь 10:21](#) -д энэ харанхуй байдлыг үзсэн байдаг.

### *ЭЗЭН Мосед*

*— Египетийн газар дээгүүр харанхуй нөмрөхийн тулд гараа тэнгэр өөд сунга гэж айлдав.*

Та тэнд харанхуйг мэдрэх болно.

### *(Тамын аймшиг!)*

Тэнд буй аймшиг маш хүчтэй байсан гэдгийг би танд хэлмээр байна. Энэ аймшиг таныг бүхэлд нь эзэмдэн авна. Хэрэв та аймшгийн кино үзэж байсан бол таны хоолойн дээр ямар нэг зүйл тээглэх шиг болдог, тэгвэл та тэр аймшгийг хэдэн зуу мянга дахин ихэсгээд үз дээ, тэнд яг л тийм байсан! Би амьдралдаа айдсыг мэдэрч байсан. Би залуу байхдаа усан дээгүүр их гулгадаг байсан. Нэг удаа бид Коко Флоридад гулгаж байсан, гэтэл сүрэг акулууд миний эргэн тойронд гэнэт гараад ирсэн. 3 метр урттай нэг акул миний хойноос гарч ирээд миний гулгагч тавцангийн хагасыг нь хүртэл үмхээд авсан. Миний хөлнөөс үмхэж доош нь татсан. Аварга том акулын аманд миний хөл зуулттай байсан. Би тэр үед итгэгч биш байсан, энэ зүйл Есүст итгэхээс өмнө болсон юм. Гэнэт тэр намайг тавьсан. Бурхан түүний амыг нээсэн гэдэгт би итгэдэг. Гэвч түрхэн зуур намайг нөмөрсөн айдсыг би мэдэрсэн. Хэрэв та амьтны соёог харж байсан бол өөрийн биеэр тэр



аймшигтай зүйлийг мэдрэх айдастай харьцуулахын аргагүй. Би айсандаа дагжин чичирч байсан. Миний хажууд гулгаж байсан залуу хэдхэн метрийн цаана байсан бөгөөд акул түүний хөлийг тас тасдсан! Хүмүүс түүнийг эрэг уруу гаргаж байхад хаа сайгүй цус урсч байсан. Тэр хашгираад л байсан, нэг хөлгүй болсон байсан. Тийм болохоор би айдас гэж юу болохыг мэднэ, гэвч тамд үзсэн тэр айдас бол юутай ч харьцуулахын аргагүй, ямар ч зүйлтэй харьцуулахын аргагүй. Акуланд хазуулсан аймшиг бол хүн амьдралдаа мэдэрч болох хамгийн аймшигтай зүйлүүдийн нэг юм.

Тэгэхлээр эдгээр зүйлүүд бол хүний тамд мэдэрч болох зүйлүүд юм. [Исаиа 24:17-20](#)–д хэлэхдээ:

*Дэлхийн оршин суутчид аа. Аймшиг, нүх, занга нь чиний дээр байна. Аймшгийн дуунаас зуттагч нь нүхэнд унана. Нүхнээс авиран гарагч нь занганд орно. Учир нь орой дээрх цонхнууд нээгдэж, дэлхийн сууриуд ганхаж байна. Газар бутран эвдэрч, газар хагарч, газар хүчтэй донсолно. Дэлхийн архичин шиг гуйвж, овоохой шиг ганхдаг.*

Хагас жилийн өмнө Тед Коппел “Шөнийн шугам” зурагтын танилцуулгыг бэлтгэж байх явцдаа Америкийн хэсэг шоронгуудаар явж, хонож үзжээ. Тэнд ямар их чанга дуу чимээтэй байсанд тэр итгэж чадахгүй байсан гэдэг, хүн бүр хоолойныхоо чадлаар орилж байсан учраас унтаж чадаагүй гэдэг. Тэр телевизэд өгсөн ярилцлагадаа хүмүүс тэнд шөнөжингөө хэрхэн орилж хашгирч, гинганаж байгааг сонсоод маш их цочирдсон гэдэг. Тэгвэл дэлхий дээр хүртэл шоронд хүмүүс ингэж хашгирдаг боловч тамын аймшигтай дуу чимээтэй харьцуулшгүй. [Иов 18:14](#)–т Эзэнийг эсэргүүцэгч хүний хорон муу зам бол...

*Тэрээр өөрийн майхны аюулгүй байдлаас таслагдсан бөгөөд тэд түүнийг аймшгуудын хааны өмнө аваачдаг.*

Муу ёрын сүнс бол гарцаагүй аймшгийн Хаан юм.

*(Там дахь эзгүйрэл)*

Би өрөөнөөс гараад нэг зүг уруу харсан, надаас 15 км-ийн зайд галын асч буй дөлнүүд харагдсан. 15 км гэдгийг би мэдэж байсан. Тэр галтай нүх хөндлөнгөөрөө 5 км орчим, галын дөлнүүд нь тэнгэр баганадсан өндөрт асахдаа тамын орчны нэгээхэн хэсгийг харуулж байсан.

Харанхуй байдал нягт байсан, ямар ч гэрлийг залгиж байсан. Гэвч асч буй галын дөлнүүдийг харж чадаж байсан. Тамын орчны бүх байдал бор өнгөтэй, эзгүй харагдаж байсан. Тэнд ямар ч ногоон навч, амьдралын ямар ч шинж тэмдэггүй, зөвхөн чулуунууд, хар бохир тэнгэр, утаа суунаглан буй тэнгэр байсан. Галын асч буй дөлнүүд надад харагдахаар маш өндөрт асч байсан. [Дэд хууль 29:23](#)–т нэгэн ишлэл байдаг.

*"Энд тэндгүй хүхэр давс болж, галд шатан, тариа ч тарьж болохгүй, үржил шимгүй, өвс ногоо ч ургаагүй байгаа нь ЭЗЭН уур хилэнгээрээ хөмрүүлсэн Содом, Гоморра, Адма, Зебойимын сүйрэл шиг болжээ" гэж хэлнэ.*

Тамд ямар ч амьдрал байхгүй байсан. Амьдрал оршин тогтнодоггүй тэр газар надад сонин санагдаж байсан. Дэлхий дээр бид ургамал мод, цэнгэг агаараар амьсгалдаг. Гэвч тэнд бүх зүйл үхмэл байсан.

*(Халуун агаар)*

Халуун агаар маш бөгчим байсан, энэ тухай дүрслэн хэлсэн байдаг. [Дэд хууль 32:24](#)

*Тэд өлсгөлөнгөөр үрэгдэн, гал шиг халуун, гашуун сүйрлээр сөнөх болно. Би бас тэдэн уруу араатны шүд, тоос шороонд мөлхөгчдийн хорыг илгээнэ.*

[Иуда 1:7](#)

*Үүнчлэн Содом, Гоморра болоод эргэн тойрных нь хотууд эдгээрийн нэгэн адилзавхайралд автагдан, өөр гаж махан биеийн араас явсан тул мөнхийн галын шийтгэлд өртөхийн жишээ болдог юм.*

[Дуулал 11:6](#)

*Тэрээр хорон муу хүн дээр тор буулгах бөгөөд гал, хүхэр болон түлэх салхи тэдний аяганы хувь хишиг болох юм.*

Тамд ийм зүйлүүд болдог, тэнд маш халуун. Энэ бүх зүйлүүд таныг хөнөөх юм шиг боловч та үхэхгүй амьд байсаар л байна. Эдгээрийг та туулахаас өөр аргагүй. Би амар тайван байж, хүмүүсийн хашгирч буй дуунаас холдохыг хүсч байсан, тэндээс гарахыг хүсч байв. Энэ нь яг л хүнд өдрийн дараа гэртээ ирж амар тайван байхыг хүсэхтэй адил зүйл юм. Гэвч тэнд бүх дуу чимээ, хашгирааныг тэсч гарахаас өөр аргагүй, гэхдээ та тэнд үүрд үлдэх болно. [Исаиа 57:21](#)–д хэлэхдээ:

*Хилэнцтэнд амар амгалан байхгүй" гэж миний Бурхан айлдаж байна.*

Тамд та бас нүцгэн байх болно. Үүнийг бас л тэсч гарахаас аргагүй зүйлүүдийн нэг юм. Ичгүүртэй зүйл! [Езекиел 32:24](#)–т тамын нүхэн дэх ичгүүрийн тухай хэлсэн байдаг.

*Елам тэнд байгаа бөгөөд түүний хамаг олон түмэн нь түүний булшны эргэн тойронд байна. Тэд бүгд алагдагсад бөгөөд илдэнд унасан, хөвч хөндүүлээгүй хүмүүс юм. Тэд газрын хамгийн доод хэсэгт очсон. Амьдын газарт тэд айдсыг төрүүлэгчид юм. Тэд нүхэнд орогсодтой хамт өөрсдийн ичгүүрийг үүрсэн.*

Бас [Иов 26:6](#)

*Түүний өмнө Үхэгсдийн орон нүцгэн бөгөөд Сүйрлийн Газар ч бүтээгдэж халхлагдаагүй.*

Энэ нь Бурхан тамыг ажиглан харж байдаг гэсэн утгатай. Тамд та тэсч гарахаас аргагүй нүцгэн байдалтай байх болно.

*(Хуурай байдал)*

Тамд ус байхгүй, ямар ч ус байхгүй. Агаар мандалд нь ямар ч чийг, усны шинж тэмдэгтэй зүйл байхгүй. Маш хуурай учраас та нэг дусал ч болтугай ус амсахыг хүснэ. Энэ яг л [Лук 16:23-24](#) хэлсэнтэй адил юм.

*Тийнхүү баян байсан хүн Үхэгсдийн оронд тарчлан байхдаа хараагаа дээшлүүлж, тэртээд байгаа Абрахамыг болон Түүний өвөр дэх Лазарыг харав. Тэгээд тэр "Абрахам эцэг ээ, намайг өршөөгөөч. Лазарыг нааш нь явуулаач. Тэр хурууныхаа үзүүрийг усанд дүрээд хэлийг минь сэрүүцүүлэг. Учир нь би энэ галд амь тэмцэн байна.*

Абрахам түүнд “Хүү минь, санагтун” гэж хэлэхэд тэр ах дүү нарынхаа тухай ярьж эхэлсэн. Тэр түүнд хурууныхаа үзүүрийг усанд дүрээд ядаж нэг дусал ус ч болтугай өгөхийг хүсч байсан. Нэг дусал ус түүнд хамгийн үнэтэй зүйл байсан гэвч та тамаас дусал усыг ч олж чадахгүй. Ам цангаж байгааг мэдрэх хэцүү байдаг. Та өөрийгөө Үхлийн хөндийгөөр амандаа хөвөн зулгаатай марафон гүйлтэд олон өдөр гүйж байна гээд төсөөл дөө. Тэнд та дусал ч болтугай ус уухыг хүссэн тийм хуурай, эзгүй, цөхрөнгүй байдлыг мэдрэх болно.

Энэ Бичээсээс олж харсан бас нэг зүйл бол там ба тэдний хооронд, Диваажин ба Тамын хооронд гүн ангал байсан явдал юм. Баян хүн Абрахамыг алс хол сууж байхыг харсан. Гэвч энгийн нүдээр тэр яаж Лазар, Абрахам хоёрыг таньсан бэ? Нэгдүгээрт тэр Абрахамыг огт харж байгаагүй, тэгээд түүнээс асар хол байгаа хүнийг тэр яаж таньсан бэ? Тамд та аливаа зүйлийг тодорхой сайн мэдэж байдаг. Та тэнд миний хэлж байгаагаар хол ойр, өндөр намын хэмжээг тодорхой сайн мэдэж байдаг.

Дараа нь нэг муу ёрын сүнс намайг шүүрэн авч, өрөө уруу буцаан авчирч дахин тамлан зовоож эхэлсэн. Би энэ тухай дахиж ярихыг хүсэхгүй байна, учир нь энэ тухай эргэн санахыг хүсэхгүй байна. Тэд миний гавлыг бяцалж эхэлсэн. Нэг муу ёрын сүнс намайг шүүрч аваад гавлыг минь бяцлаж эхэлсэн. Би өршөөл гуйн хашгирсан боловч ямар ч нэмэргүй байв! Энэ удаа тэд миний хөл, гараас татаж, тал тал тийш нь тас татан хаяхыг оролдож байсан. “Би энэ бүгдийг тэсч чадахгүйнээ!” гэж бодсон.

*(Нүхний хажууд)*

Гэнэт ямар нэгэн зүйл намайг шүүрэн авч өрөөнөөс гаргасан. Тэр бол Эзэн байсан гэдэгт итгэдэг, гэвч тэр үед би энэ тухай мэдэхгүй байсан. Би тэнд итгэгч биш хүн шиг байсан бөгөөд тийм зүйлийн тухай мэдэхгүй байсан. Там уруу би Эзэний тухай юу ч мэддэггүй хүн болон очсон байсан. Намайг миний харсан галын хажууд тавьсан бөгөөд галтай нүхний хажууд зогсож байсан. Би дээшээгээ хоолой маягийн зүйл эргэлдэж байсан том агуй шиг юмны дотор зогсож байсан.

Галын асч байгаа дөлөн дундаас би шатаж байгаа хүмүүсийг, өршөөл гуйн хашгирч орилж байгаа хүмүүсийг харсан. Би тийшээ очихыг хүсэхгүй байсан. Миний дөнгөж саяхан амссан зовлон надад

хангалттай бөгөөд галын дөл намайг бүр ч долоон дор төөнөн шатааж байв. Тэнд байсан хүмүүс галан дундаас гарахыг хүсч орилолдож байв.

Галтай нүхний амсар дээгүүр аварга том амьтад эгнэн зогссон байсан бөгөөд хүмүүс галаас мөлхөн гарахыг оролдох болгонд шүүрч аваад буцаагаад шидэж байв. “Өө, энэ газар бүр ч аймшигтай, аймшигтай, аймшигийн газар юм байна” гэж бодсон.

Та тамд өлсөж, цангаж, ядарч туйлдах болно. Энэ бүх зүйл зэрэг болж байсан. Тамд бас унтаж амарна гэж бодсоны ч хэрэггүй. Та дэлхий дээр байхдаа амрах хэрэгтэй учраас унтдаг. Таны биед нойр хэрэгтэй. [Илчлэлт 14:11](#)–д хэлэхдээ:

*Тэдний зовлон тарчлалын утаа үеийн үед суунаглана. Араатанд ба түүний хөрөгт мөргөгсөд, Түүний нэрийн тэмдгийг хүлээн авагч аливаа хүн өдөр ч, шөнө ч амрахгүй.*

Та тэнд хэзээ ч унтахгүй. Унтахгүй байна гэхээр ямар хэцүү болохыг та төсөөлж байна уу.

Усны тухай [Зэхариа 9:11](#)-д

*Мөн чиний хувьд ч гэсэн, Миний гэрээний цус чамтай хамт байгаа учир Би чиний хоригдлуудыг усгүй нүхнээс чөлөөлнө.*

Тамд ямар ч ус байхгүй.

Там дэлхий төвд байдгийг би мэдсэн. Там бол дэлхийн төв дунд байдаг. Би дэлхийн гүнд 6000 орчим км гүнд байсан гэдгээ мэддэг. Дэлхийн диаметр 12700 орчим км гэдгийг бид мэднэ. Түүний хагас хэмжээ нь 6350 км гэсэн үг. Би 6000 орчим км гүнд байсан. [Эфес 4:9](#)–т Есүс дэлхийн доод хэсэгт очсныг “*Тэр дээш гарсан” гэдэг нь Тэр бас газрын доод хэсэгт буусан гэдгээс өөр ямар утгатай вэ?*” гэж хэлсэн байдаг.

[Тооллого 16:32](#)-т хэлэхдээ:

*... газар амаа нээн, тэднийг болон гэрийнхнийг нь, мөн Корад хамаатай бүх хүнийг эд хөрөнгөтэй нь хамт залгилаа.*

Энэ бол тамын одоо байгаа газар юм. Эцсийн өдөр Там ба Үхэл галтай нууранд хаягдаж дараа нь гаднах харанхуй ертөнц уруу хаягдах болно. Энэ зүйл Шүүлтийн өдөр болох бөгөөд одоохондоо там дэлхийн төвд байна.

*(Муу сүнснүүд)*

Би галтай нүхний хажууд зогсож байсан бөгөөд янз бүрийн хэлбэр хэмжээ бүхий сонин, гаж хэлбэртэй бузар муу сүнснүүд нүхний амсрыг тойрон эгнэн зогссон байхыг харсан. Эдгээр амьтад зэрэмдэг, жигшмээр том, жижиг амьтдууд байсан. Бас аварга том аалзнууд, 3 метр орчим өндөр аалзнууд байсан. Хархнууд, могойнууд, өтнүүд байсан, Библид өтний тухай дурдсан байдаг ([Исаиа 14:11](#)). Хаа сайгүй ой гутам муухай амьтад байсан, харин тэд хананд гинжлэгдсэн байсан. “Яагаад эдгээр амьтад хананд гинжлэгдсэн байгаа юм бол?” гэж бодсон. Би тэр зүйлийг ойлгоогүй боловч Бичээст [Иуда 1:6](#)-д энэ тухай хэлсэн байдаг.

*Эрх мэдэл бүхий байр сууриа сахилгүй, харин ч орон байраа орхин одсон тэнгэр элч нарыг Тэрээр агуу их өдрийн шүүлт болтол мөнхөд хүлээстэй нь харанхуйд хорьжээ.*

Магадгүй би энэ зүйлийг харсан байх, би сайн ойлгоогүй боловч энэ бол миний харсан зүйл. Тэд намайг барьж авч чадахгүй гэдгийг мэдээд би баярлаж байсан. Тэд бүгд намайг хорсол заналтайгаар үзэн ядаж байсан. Энэ бас миний ойлгож чадаагүй зүйлүүдийн нэг бөгөөд тэд зүгээр нэг жигшүүртэй амьтад байгаагүй харин хүмүүсийг үзэн ядах асар их хорсол, зэвүүцэлтэй байсан. Тиймээс би тэднийг хананд гинжлэгдсэн байгааг хараад маш их баярласан.

Дараа нь би галтай нүхнээс зугтаж дээшээ хоолойгоор өгсөж эхлэв. Удалгүй харанхуй нөмөрсөн ч ханан дээгүүр байгаа муу сүнснүүдийг харж чадаж байв. Тэд ер бусын их хүч чадалтай гэдгийг мэдсэн. “Энэ амьтдыг хэн дийлж чадах вэ? Хэн ч тэдний эсрэг тэмцэж чадахгүй” гэсэн бодол төрж байсан. Намайг айдас бүрэн эзэмдсэн байсан учраас арай хийн явж байв.

*(Итгэл найдваргүйн дунд)*

Там дахь хамгийн муухай зүйл бол, бүр тарчлал зовлонгоос ч илүү муухай байсан зүйл бол дэлхий дээр амьдрал үргэлжилсээр байгаа гэдгийг ойлгох явдал байсан. Дэлхий дээр байгаа ихэнх хүмүүс дор ийм ертөнц байдгийг төсөөлөх ч үгүй. Тэд энэ ертөнцийн үнэн бодит байдлыг болон энд олон тэрбум хүн хэрхэн зовон тарчилж, нэг удаа ч болов эндээс гарахыг оролдож, ямар ч гарцгүй болж байгааг мэдэхгүй. Энд нэгэнт ирсэн хүмүүст ахин боломж олдохгүй бөгөөд тэд Есүсийг хүлээж аваагүйдээ өөрийгөө зүхэн үүрд мөнхөд хоригдсон аж.

Энэ бол тамын хамгийн муухай зүйл бөгөөд тэндээс гарах өчүүхэн ч найдлага байхгүй. Би тэнд үүнийг маш сайн мэдэж байсан. Би тэнд мөнх байдлыг мэдэрч байсан. Дэлхий дээр бид тийм зүйлийг мэдэрч чадахгүй боловч тамд би мөнх байдал гэж юу болохыг мэдэрч байсан. Тэнд би үүрд хоригдох бөгөөд гарах ямар ч найдлага байхгүй. Би эхнэрээ бодсон. Дахиж түүнтэй хэзээ ч уулзаж чадахгүй гэж бодсон. Би эхнэртээ, хэрэв дэлхий дээр ямар нэгэн зүйл, газар хөдлөлт ч юм уу, ямар нэг аймшигтай юм тохиолдох юм бол “Би чамайг олох болно, чамайг олоод очих болно, хэрэв бид ямар нэг байдлаар салахын бол чамайгаа олоод очих болно” гэж үргэлж хэлдэг байсан. Харин тамд би түүнийг хэзээ ч олж чадахгүй. Түүнийг би одоо дахин хэзээ ч харж чадахгүй. Тэр намайг одоо хаа байгааг өчүүхэн төдий ч мэдэхгүй байгаа, түүнтэй дахин хэзээ ч уулзаж чадахгүй. Ийм бодол намайг аймшигтай ихээр зовоож байв. Түүнтэй ярьж чадахгүй, түүн дээр очиж чадахгүй, эндээс гарах ямар ч найдлага байхгүй. Дэлхий дээр бидэнд үргэлж найдлага байдаг. Хорих лагерьт байгаа хүмүүст хэзээ нэгэн цагт тэндээс мултарна гэсэн найдлага байдаг, ядаж л үхчих юм бол тэр газраас зайлж чадна. Бид хэзээ ч найдлагагүй байдлыг мэдэрч байгаагүй. [Исаиа 38:18](#)–д хэлэхдээ:



*Учир нь Үхэгсдийн орон Танд талархаж чадахгүй, үхэл Таныг магтаж чадахгүй. Нүхэнд орогчид нь Таны итгэмжит байдалд найдаж чадахгүй юм.*

Тэнд ямар ч итгэл найдвар байхгүй. Цорын ганц үнэн бол Есүс, тэр бол үнэн.

*(Есүс ирэв)*

Хоолойгоор дээш явж байхдаа би хязгааргүй айдас, итгэл найдваргүй байдал, муу сүнснүүдээс айх аймшгаар дүүрэн байв. Гэнэт Есүс гарч ирсэн! “Эзэн, таныг магъя”, Есүс Эзэн гарч ирсэн. Хурц гэрэл орчныг гэрэлтүүлсэн. Би түүний гаднах дүр төрхийг харсан. Маш хурц гэрэлтэй байсан учраас түүний царайг харж чадаагүй. Би шууд л өвдөг дээрээ сөхөрч унасан. Би юу ч хийж чадахгүй зөвхөн түүнийг магтаж байсан. Нэг секундын өмнө би ямар ч итгэл найдваргүй үүрд алдагдсан байсан харин Есүсийг аль хэдийн мэддэг байсан учраас тэр газраас мултартсан. Тэндээс хүмүүс явж чадахгүй байхад харин би явсан, яагаад гэвэл би аврагдсан байсан. Ганцхан Есүсээр дамжин хүн энэ газраас гарч чадна гэдгийг би ойлгосон. Тэр бол энэ газраас мултрах цорын ганц арга зам.

Илчлэлт 1:6-д Иохан тэнгэрийн улсад Есүсийг харсан бөгөөд түүний дүр төрх нар шиг гэрэлтэж байсан гэж хэлдэг. Иохан түүнийг хараад газар үхэтхийн унасан гэдэг. Энэ нь яг надад тохиолдсон зүйл юм. Би түүний хөл дор бүхий л биеэрээ унасан байсан. Магадгүй би түүнээс олон зүйлийн тухай асуух байх гэж та бодож байсан байх, гэвч хэрэв та тэнд миний оронд байсан бол зөвхөн түүнийг магтаж, алдаршуулж, түүний авралд баярлан талархахаас өөр аргагүй.

Би тайвширч, юм бодохтойгоо болж ирэхэд Эзэнд юм хэлэхээр бодол дотроо бодсон, би чанга дуугарсан гэж бодохгүй байна, намайг дөнгөж бодож эхлэхэд Тэр надад хариулсан. “*Эзэн минь ээ, та яагаад намайг энэ газарт ирүүлсэн юм бэ? Яагаад намайг энд авчирсан юм бэ?*” гэж асуусан. Тэр надад **“Яагаад гэвэл хүмүүс энэ газрыг байдаг гэдэгт итгэдэггүй. Миний зарим хүмүүс хүртэл энэ газрын үнэн бодит байдалд итгэдэггүй”** гэж хэлэв. Би энэ зүйлийг сонсоод маш их цочирдсон. Хрисчин хүмүүс там байдаг гэдэгт итгэдэг гэж бодож байсан. Гэвч бүх Христчин хүмүүс тамын бодит байдалд нэг бүрчлэн итгэддэггүйг мэдсэн. “*Та яагаад намайг энэ газар авчрахаар сонгосон юм бэ?*” гэж би асуусан. Тэр надад юу ч хариулсангүй.

Тэр яагаад намайг тэр газар уруу аваачихаар сонгож авсныг би мэдэхгүй. Би бол тийм газар очих эрхгүй өчүүхэн нэгэн. Эхнэр бид хоёр аймшгийн кино үздэггүй, муу зүйлийг үзэн яддаг. Тэр ч байтугай би халуун зуны цагт дургүй. Надад зүгээр л муухай санагддаг. Ямар ч эмх замбараа, дэг журам байхгүй, бохир заваан санагддаг. Би бүх зүйл эмх цэгцтэй, онц сайн байхад дуртай. Тэр миний асуултад хариулаагүй. Тэр надад **“Би энэ газрыг үзэн яддаг гэдгийг тэдэнд хэл, миний бүтээлүүдээс хэн нь ч, нэг ч хүн энд ирэхийг би хүсдэггүй, нэг ч хүн энд ирэхийг хүсдэггүй! Энэ газрыг би тэдэнд зориулж бүтээгээгүй. Энэ бол муу ёрын сүнснүүд, диаволиудад зориулагдсан газар. Тэдэнд очиж, хэлэгтүн! Би чамд үгийг өгсөн, тэдэнд хэлэгтүн!”** гэж хэлсэн.

“*Гэвч Эзэн минь ээ, тэд надад итгэхгүй шүү дээ. Намайг галзуу солиотой эсвэл хар дарж зүүдэлсэн гэнэ шүү дээ. Та ингэж бодохгүй байна гэж үү?*” гэж бодсон. Намайг ийн бодож байтал Эзэн **“Тэднийг ятгах нь чиний ажил биш. Тэр бол Ариун Сүнсний ажил. Зөвхөн чи хэлэх ёстой!”** гэж хэлсэн. Миний дотор **“Гүйцэтгэе, Эзэнтээн! Би явж, хэлэх болно”** гэж хэлэх шиг

болсон. Та бусад хүмүүс таны тухай юу гэж бодох бол гэж санаа зовох хэрэггүй, зөвхөн Бурханы хий гэсэн бүгдийг хийвэл үлдсэнийг нь Тэр хийх болно. Амен? *“Эзэн минь, тэд яагаад намайг тэгж их үзэн ядаад байсан бэ?”* гэж би асуув. **“Яагаад гэвэл чи миний дүр төрхөөр бүтээгдсэн, тэд намайг үзэн яддаг”** гэж хэлсэн. Энэ бол диавол яагаад хүмүүсийг үзэн ядаж, там уруу аваачих гэж мэхэлдгийн учир юм. Бас тэр хүнийг өвчин тахлаар өвтгөж, Бурханы бүтээлийг зовоон шаналгахын тулд чадах бүхнээ хийдэг.

*(Бурханы амар тайван)*

Дараа нь Бурхан намайг өөрийнхөө бодлоор дүүргэсэн. Тэр намайг хүн төрөлхтөнд хандсан түүний зүрх сэтгэлийн хайрыг мэдэхийг зөвшөөрсөн. Би түүний хайрыг тээж чадахгүй байсан, би арай чүү тэсч байсан. Хүн төрөлхтөнд хандсан түүний хайрыг та энэ биедээ тээж чадашгүй. Бид өөрсдийн эхнэр, хүүхдүүддээ ямар их хайртай билээ? Бурханы бидэнд зориулсан хайрыг хүний хайртай харьцуулшгүй. Түүний хайр бол бидний хайр ба бидний хайрын хүч чадлаас даван гарсан эцэс төгсгөлгүй, хязгааргүй хайр юм. Энэ нь яг [Eph 3:19](#)–т **“Мэдлэгийг давдаг Христийн хайрыг мэдсэнээр та нар...”** гэж хэлсэнтэй адил зүйл юм. Энэ бол таны оюун ухаан, мэдрэхүйгээс даван гарсан зүйл, та түүнийг өөртөө тээж чадашгүй. Нэг хүний төлөө байсан ч өөрийгөө зориулах түүний хайр хичнээн их болохыг мэдээд би итгэж чадахгүй байсан. Түүний бүтээл энэ харанхуй газар ирэхэд түүний зүрх сэтгэл хичнээн их өвдөж байсныг харсан. Эзэний сэтгэл маш их өвдөж байсан, тэр тийш очиж байсан хүн болгоны төлөө гашуудан уйлж байсан. Эзэнийг хараад би маш их уйтгар гунигтай болсон.

Би түүний зүрх сэтгэлийг мэдэрсэн, тэр намайг өөрийнхөө зүрх сэтгэлийн нэг хэсгийг мэдрэхийг зөвшөөрсөн. Тэгээд, *“Би явж, гэрчлэх болно, эцсийн амьсгалаа хураатал Есүс хичнээн сайн Эзэн болохыг дэлхийд хэлэх болно”* гэж бодсон. Энэ бол сайн мэдээг тараана гэсэн үг юм. Эзэний сайн мэдээ бол сайн мэдээ юм. Хүмүүс сайн мэдээг сонсох хэрэгтэй! Бид энэ зүйлийг тараах хэрэгтэй. Хүмүүс сайн мэдээг сайн мэддэггүй. Бид тэдэнд Бурхан хичнээн сайн Эзэн болохыг, энэ газрыг хичнээн их үзэн яддагийг хэлэх хэрэгтэй.

Тэр бас надад **“Би тун удахгүй ирнэ гэдгийг тэдэнд хэл”** гэсэн. Дахин тэр **“Би тун удахгүй ирнэ гэдгийг хэл”** гэж хэлсэн. Яагаад би тэр үед түүнээс *“Эзэн минь ээ, энэ чинь юу гэсэн үг вэ?”* гэж асуугаагүй юм бол гэж би бодож байсан. Та нар ч бас тэгж бодох байх. Гэвч би асуугаагүй. Та ч бас тийм зүйлийг асуухгүй байх байсан болов уу. Яагаад гэвэл та түүний хажууд зөвхөн түүнийг алдаршуулан магтахыг хүснэ. Түүний хажууд зогсож байхад түүнээс ирж байсан Бурханы амар тайванг дүрслэн хэлэхийн аргагүй байсан. Би олон удаа тосолгоотой үйлчлэлүүдэд сууж байсан, гэвч Бурханы хажууд зогсож байхад түүнээс ирэх амар тайван, хайрыг юутай ч зүйрлүүлэхийн аргагүй байсан.

Дараа нь би дээшээ харахад ханан дээгүүр байгаа зэрлэг амьтад шоргоолж шиг харагдав! Тэд яг л шоргоолж шиг харагдаж байсан! Тэд хэдийгээр аварга том байсан ч гэлээ Бурханы хүч чадлын дэргэд, түүний гайхамшигт хүч чадлын дэргэд ханан дээр шоргоолж шиг харагдаж байсан. Би тэр байдлыг ойлгохгүй байсан. *“Эзэн минь ээ, тэд яг л шоргоолж шиг харагдаж байна!”* гэхэд Есүс **“Чи тэднийг миний нэр дээр хүлж, зайлуулах хэрэгтэй”** гэж хэлэв. Би *“энэ бол Бурхан өөрийн сүмүүдэд өгсөн хүч чадал нь”* гэж бодсон. Эдгээр хэрцгий амьтдыг Есүсийн хүч чадалгүйгээр юу ч дийлж чадахгүй! Тэд хэрцгий боловч Есүстэй хамт байвал тэд юу ч биш! Миний дотор зориг орж, тэдгээр зэрлэг амьтад уруу *“муу бяцхан амьтдаа, та нар намайг тамлаж, тас тасдахыг оролдож байсан биз дээ. Одоо тэгээд хүрээд ирээч. Та нарт үзүүлээд өгье л дөө”* гэж хэлж байсан. Магадгүй миний төрөлхийн зан чанар минь хөдөлсөн байх л даа, *“Есүс ээ, тэдэнд үзүүлээд өгөөрэй”* гэж хэлмээр санагдсан.

(Тамаас яваа)

Бид тамаас дээш явсаар дэлхийн гадаргуугаас дээш гарсан. Бид дээшээ яваад л байсан, яагаад гэвэл бид туннелээс гараагүй байсан. Удалгүй би ямар ч туннел харахаа больж харин бидний дор хуйлран эргэлдэж буй аварга том зүйлийг л харж байсан. Бид дээшээгээ яваад л байсан, тэндээс бүрмөсөн гарах хэрэгтэй байсан. Бид хоолойн дээд хэсэгт хүрэхэд дор дэлхий байгааг харсан. Иймэрхүү өндөртэй харагдаж байсан. Дэлхийн дугуйрсан хэсэг иймэрхүү байдалтай харагдаж байсан. Дэлхийг харахад үнэхээр гайхамшигтай байсан! Бурхан надад тийм гайхалтай зүйл харуулахыг зөвшөөрсөн гэдгийг би мэдсэн. Хэрэв тэр хүсвэл бид хоолойгоос өөр замаар гарч болох л байсан. Бага байхдаа би үргэлж дэлхийг сансраас харахыг хүсдэг байсныг минь Бурхан мэддэг байсан. Магадгүй би “Оддын аялал”-ыг их үздэг байсан байх л даа. Би зүгээр л дэлхийг жинхэнэ байдлаар нь, хэрхэн сансарт хий агаарт тогтож байгааг нь харахыг хүсдэг байсан. Яг л Библид [Иов 26:7](#)–д хэлдэг шиг:

*Тэрээр хоосон газрын дээр умардыг дэлгэж, хоосон юман дээр газар дэлхийг өлгөдөг.*

Хэрэв та дэлхийг харахын бол “Энэ зүйл яаж ингэж агаарт тогтдог юм бол? Түүнийг юу гайхамшигтай болгодог юм бол?” гэж бодно. Бурхан бүхнийг удирддаг. Намайг дүүргэж байсан Бурханы хүч чадал бол агуу гайхамшигтай байсан. Түүнд маш их хүч чадал байдаг. Бүх зүйл түүний гарт байдаг. Тэр газарт унах таны нэг ширхэг үсийг ч хүртэл мэддэг. Түүний зөвшөөрөлгүйгээр тэнгэрийн нэг ч шувуу газар унахгүй. Намайг ийм бодлууд дүүргэж байсан. Бурхан бол агуу хүч чадалтай. Түүний хүч чадал намайг дүүргэж байсан. Бурхан дэлхийн тойрог дээр суудаг гэсэн ишлэл [Исаиа 40:22](#)–т байдаг. Би дэлхийн тойрог дээр сууж байсан. Би тэр байтугай “Эзэн минь ээ, Христопфероос өмнө амьдарч байсан тэдгээр хүмүүс хэрхэн Бичээс дээр дэлхийг бөөрөнхий гэж мэдээд бичсэн юм бол?” гэж бодсон. Хүмүүс дэлхийг хавтгай гэдэг байсан шүү дээ. Та нар мэднэ.

Бид дэлхий уруу буцан ирэхэд дэлхийн гадаргыг дайран өнгөрсөн. Бид дэлхийг тойрон байдаг халуун давхаргыг нэвтлэн гарч байгааг мэдсэн. Би зүгээр л энэ тухай мэдэж байсан. Тэр байтугай “Бурхантай надтай хамт явж байна. Тэр яаж энэ давхаргыг нэвтлэн гарч байгаа юм бол” гэсэн тэнэг бодол орж ирж байсан. Тэдгээр давхаргууд сансарт хэрхэн бие биетэйгээ төгс өнцгөөр уусан шингэсэн байдгийг та мэдэх үү? Бид ямар ч саадгүйгээр давхаргыг нэвтлэн гарсан. Гайхах юм юу ч байгаагүй. Мэдээж Эзэн нүдээ том болгон “Би үүнийг хийж чадна” гэж хэлэх байсан байх л даа. [Дуулал 47:9](#)–т нэгэн ишлэл байдаг:

*... Учир нь газар дэлхийн бамбайнууд бол Бурханых...*

Тэр бүх зүйлийг, бүх зүйлийг удирддаг. Би түүнээс салахыг хүсэлгүй түүний оршихуйд байгаад л баймаар байсан. Бид Калефорнийг маш хурдан явж өнгөрсөн. Дараа нь манай байшин харагдахад дээвэр дээрээс гэр дотрохоо харж байсан. Миний бие шалан дээр эвхрэн хэвтэж байгааг хараад би үнэхээр их цочирдсон. “Энэ би байж таарахгүй, би чинь энд байна шүү дээ!” гэж бодсон. Хүн хэзээ ч өөрийгөө хоёр байгааг хардаггүй шүү дээ, та мэднэ. Өөрийгөө шалан дээр хэвтэж байгааг хараад “Энэ хүн би биш” гэж бодож байсан. Тэр үед Паулын “бид бол майхан” гэж ([2 Коринт 5:1](#)) хэлсэн үгс маш тод санагдсан. Би “энэ бол зөвхөн майхан, энэ бол юу ч биш түр зуурын юм. Энэ яах аргагүй би мөн” гэж бодсон. Энэ бол мөнх байдал гэж юу юм бэ гэдгийг харуулдаг. Бидний хичнээн их санаа тавьдаг энэ амьдрал бол замхран алга болох уур манан шиг, [Иаков 4:14](#)–т “Амь чинь маргааш ямар байхыг та нар мэдэхгүй. Учир нь та нар хэсэг зуур

*үзэгдээд дараа нь алга болох уур манан шүү дээ”* гэж хэлсэн шиг амьдрал маш богино. Та 100 жил амьдарлаа ч энэ нь юу ч биш. Хэзээ нэгэн цагт уур болон замхран алга болно. Тэгээд би *“Бид Бурханы төлөө амьдрах хэрэгтэй”* гэж бодсон. Энэ дэлхий дээр хийж байгаа бүхэн маань мөнхийн утга учиртай. Бид гэрчлэх хэрэгтэй. Бид энэ байшингаас гарч, сүнснүүдийг аврах хэрэгтэй. Бид өөрсдөө уягдаж хүлэгдсэн амьдралын аар саар зүйлүүдэд үнэндээ санаа зовох хэрэггүй. Бид энэ байшингаас гарч сайн мэдээг тараах хэрэгтэй. Яагаад гэвэл удахгүй энэ бүгд төгсөх болно.

Шалан дээр хэвтэж байгаа өөрийнхөө биеийг хараад би, энэ нь яг л машинаасаа гараад машинаа гаднаас нь хараад зогсож байгаатай адил санагдсан. Энэ бол та өөрөө биш харин машин чинь байна гээд бод доо. Таны бие таныг нэг газраас нөгөө газарт хүргэж өгдөг зүйл шиг. Надад яг ингэж л санагдаж байсан. Энэ нь таныг дэлхийгээр авч яваа ямар нэгэн сав шиг. Тэгээд би *“Эзэн минь ээ, надаас битгий яваач, надаас битгий яваач”* гэж бодсон. Би түүнтэй хэсэгхэн хугацаанд ч гэсэн хамт байхыг хүссэн. Тэр явсан. Би биендээ эргэн орж, миний биеийг ямар нэгэн юм татаж байгаа юм шиг миний ам, хамар сорогдон буцаад биендээ орсон.

Дараа нь түүнийг явсны дараа бүх айдас, тамлал, шүүлтүүд миний оюун ухаанд эргээд ирэх шиг болсон. Учир нь *“төгс хайр нь айдсыг хөөн зайлуулна”* гэж хэлсэн байдаг ([1 Иохан 4:18](#)). Би төгс хайрын дэргэд байсан, тэгээд тэр намайг гэнэт орхин явахад тамын бүх айдас, аймшиг зовлонгууд надад эргэн ирсэн. Би тэвчиж чадахгүй байсан! Тэсэшгүй хүнд байсан! Би орилж хашгирч байсан. Би асар их зовлонд унасан. Би энэ айдастайгаа амьдарч чадахгүй байсан. Миний бие ийм аймшгийг тээж чадахгүй гэдгийг би мэдэж байсан. Та ийм дарамт шахалтыг хэзээ ч тэсч чадахгүй. Таны бие ийм зүйлийг даван гарахад хэтэрхий сул дорой. Тийм учраас би залбирсан, *“энэ зүйлийг миний оюун ухаанаас зайлуулаач”* гэж залбирч л чадаж байсан.

Энгийн амьдрал дээр бид ийм гамшгаас салахын тулд янз бүрийн зөвлөгөө, эмчилгээнд явдаг гэвч Бурхан энэ зүйлийг надаас авч хаясан, надаас энэ гамшгийг авч хаясан. Тэр надад энэ тухай дурсамжийг үлдээж бүх аймшиг, гамшгуудаас намайг салгасан. Би үүний төлөө Бурханд маш их талархаж байна.

Үүний дараа надад олон зүйл тохиолдсон, надад тохиолдсон бүх зүйлийг Бурхан хэрхэн баталж байсан тухай ярих хангалттай цаг байсан бол би яримаар байна.

Хэрэв өнөөдөр энд Эзэнийг мэдэхгүй ямар нэгэн хүн байгаа бол өөрөөсөө нэг асуултыг асуугаарай. *“Би эдгээр хүмүүсийн яриад байгаа зүйлд, тэдний харсан гэж хэлээд байгаа зүйлд итгэж болох уу?”* Гэвч үүнээс илүү тамын тухай Бурханы Үгэнд юу гэж хэлэгдсэн байдгийг уншаарай. Эсвэл та *“Үгүй ээ, би энэ бүгдийг үнэн гэж итгэхгүй байна”* гэж өөрийгөө эрсдэлд оруулахыг хүсч байна уу? Та Бурханы Үгийг болон бидний танд хэлэхийг хичээж байгаа зүйлүүдийг хэрэгсэхгүй хаяж болно. Та өөрийнхөө мөнх хувь заяаг эрсдэлд оруулмаар байна уу? Тэгэх юм бол надад лав ухаалаг санагдахгүй байна. Гэвч та өөрийгөө диаволд хууртагдахыг зөвшөөрч болохгүй. Тэр том амьтад таныг тэнд хүлээж байх болно, таныг шоолон инээлдэх болно ([видеонд үзүүлсэн шиг](#)). Энэ бол тамд байгаа муу сүнснүүдийн дүр төрх юм. Танд Эзэнийг хүлээн авах боломж байсан боловч та тэр боломжийг алдсан гэж тэд таныг шоолон инээлдэх болно. Хэрэв та нэгэнт тэр газар очвол эргэж буцах ямар ч зам байхгүй. Танд тэндээс гарах ямар ч арга зам байхгүй. Та тэнд үүрд алдагдах болно.

Магадгүй та өөртөө “*Би бол дажгүй хүн. Би бол сайн хүн. Би тийм газар очих ёсгүй*” гэж хэлэх байх. Та бусадтай харьцуулахад сайн хүн байж болно. Гэвч бид өөрсдийгөө ийм байдлаар харьцуулж болохгүй. Бид өөрсдийгөө Бурханы стандартаар харьцуулах хэрэгтэй. Түүний стандарт бол биднийхээс дээгүүр. Түүний Үгэнд хэлэхдээ хэрэв та нэг л удаа худлаа ярьсан бол, амьдралдаа нэг л удаа худлаа ярьсан бол та худалч гэж хэлсэн байдаг. Хэрэв та амьдралдаа нэг л удаа юм хулгайлсан бол, цаасны хавчаар юм уу, эсвэл ажлынхаа цагаас хэдэн минут хулгайлсан бол, юу ч байж болно, нэг л удаа хулгайлсан бол та хулгайч гэж хэлсэн байдаг. Хэрэв та ямар ч шалтгаангүйгээр уурлаж, таны эсрэг ямар нэг буруу зүйл хийсэн хүнийг уучилж чадахгүй байвал, хэрэв та эмэгтэй хүний тухай завхай бодол бодож байсан бол, эдгээрийн аль нэгийг амьдралдаа нэг л удаа хийсэн бол та гэм нүгэлтэй хүн бөгөөд ийм зүйлүүд таныг тэнгэрийн улсад аваачиж чадахгүй. Энэ бүх зүйлүүд биднийг гэм нүгэлтэй гэдгийг харуулдаг. Бид бүгд гэмтэй бөгөөд өөрсдийн сайн үйлсээрээ аврагдаж чадахгүй. [Тит 3:5](#) –д хэлэхдээ:

*... тэр биднийг зөвт байдлын дотор хийсэн үйлсээр минь бус харин Өөрийнхөө өршөөлийн дагуу ... аварсан юм.*

Амен, тэгэхлээр энэ бүх зүйл та юмыг хэрхэн яаж харьцуулж байгаагаас шалтгаална. Энэ нь яг уулын хажууд бэлчиж байгаа хоньдыг хараад уултай харьцуулахын бол хичнээн гоё, хичнээн цагаан болохыг нь харьцуулж үзэхтэй адил юм. “*Хараач, энэ хоньдууд ямар гоё цагаан, ямар гоё юм бэ?*” гэж хэлэхтэй адил юм. Магадгүй цас ороход цасанд балиартаж толбодсон хоньдууд цастай харьцуулахад бохир, заваан харагдаж болно. Тийм учраас бид өөрсдийгөө Бурхантай харьцуулан үзэх хэрэгтэй. Түүний стандарт бол биднийхээс дээгүүр. Тиймээс бидэнд Аврагч хэрэгтэй. Бид өөрсдийнхөө үйлсээр аврагдаж чадахгүй. Бурхан бидэнд үнэгүй бэлэг өгсөн. Тэр [Иохан 14:6](#) “*Би бол зам, үнэн, амь мөн. Хэн ч Надаар дамжилгүйгээр Эцэгт хүрэхгүй*” гэж хэлсэн. Тэр бол тамаас аврагдах цорын ганц арга зам юм.

Хэрэв энд Эзэнийг мэдэхгүй хүн байгаа бол, урьд өмнө нь Есүсийг өөрийн Эзэн болгож амьдралдаа Аврагч болгон хүлээж аваагүй бол та өөрийн хоолойгоор, өөрийнхөө амаар түүнийг амьдралдаа урих хүртэл жинхэнэ авралыг авч чадахгүй. Тийм хүн байвал суудлаасаа босно уу. Хэрэв тийм хүн байгаа бол Есүсийг хүлээж авахын төлөө босно уу? Дьяволууд, зэрлэг амьтад таныг шоолон инээхийг бүү зөвшөөр. Танд одоо боломж байгаа дээр шийдвэрээ гаргагтун, танд хир зэрэг хугацаа байгааг та мэдэхгүй. Магадгүй маргааш үхээд тэр газар очихыг хэн ч мэдэхгүй.

Танд би хэлье, тэр газар бол хүний тэсвэр тэвчээрээс давсан маш халуун газар. Нью-Йоркийн цамхгаас үсэрч байсан хүмүүсийг бид харсан. Тэд гар гараасаа барин үсэрч байсан. Үнэхээр аймшигтай байсан. Хэрэв та өндөр газар гараад доош хараад үсэрнэ гэвэл хүний санаанд багтахгүй биз дээ. Гэвч тэдгээр хүмүүс халуун галтай тэмцэлдэж байсан. Магадгүй гал тэднийг 5 секундний дотор л шатааж, үнс нурам болгох байсан байх, тэнд 2000 градус байсан. Эрдэмтэд дэлхийн төвд 12000 градус халуун байдаг гэж үздэг. Та тэнд мөнхөд шатах болно. Хэрэв та тэнд шатахыг хүсвэл үнэхээр тэнэг хэрэг болно. Энэ бол таны цаг...

*(хөтлөгч ярьж байна)*

Библид хэлэхдээ бид бүгд гэмтэй бөгөөд Эзэний нэрийг дуудсан хүн бүр аврагдах болно гэж тодорхой хэлсэн байдаг. Есүс хэлэхдээ хэрэв чи миний өмнө, хүмүүсийн өмнө гэм нүгэлдээ гэмшвэл би чам уруу эргэх болно. Миний нэрийг миний тэнгэрлэг Эцэгийн өмнө, ариун тэнгэр элчүүдийн өмнө тунхагла. Гэвч хэрэв чи намайг хүмүүсийн өмнө эсэргүүцвэл би чамайг



Эцэгийнхээ өмнө эсэргүүцэх болно гэсэн. Таныг нэг зүйлийг хийгээсэй гэж хүсч байна. Хэрэв та урьд өмнө нь хэзээ ч хүмүүсийн өмнө Есүс Христийг өөрийн аврагчаа болгож, амьдралдаа урьж байгаагүй бол, хэрэв та тэнгэрийн улс бол таны мөнх гэр гэдэгт итгэж байгаагүй бол Есүс олон хүн цугларсан захын газар загалмай дээр нүцгэн цовдлогдохдоо таны төлөө цовдлогдож, таны ичгүүрийг өөртөө авсан гэдгийг санаарай.

Хэрэв та энэ залбирлыг чин сэтгэлээсээ хэлж залбирвал Бурхан таны сүнсийг аварч, бусдад гэрчлэх боломжийг өгөх болно. Цуглааны итгэгчид Христийг хүлээж аваагүй хэн нэгнийг санавал тэдний төлөө бас залбирна уу. **“Бурхан минь би танд итгэж байна. Та бол миний Бүтээгч. Би гэм нүгэлтэй хүн. Би таны өмнө санаандгүй болон санаатайгаар олон гэм хийж байсан. Би гэмд унасан. Би хийж болохгүй зүйлүүдийг хийж байсан. Би гэмд баригдсан хүн. Есүс би танд итгэж байна. Та бол Бурханы мөнхийн Хүү. Та бол миний болон хүн төрөлхтөний гэмийг үүрсэн Бурханы Хурга. Та миний төлөө загалмай дээр нас барсанд итгэж байна. Та гэмтэй миний төлөө гэмгүй ариун цусаа урсгасан. Та нас барж, гурван өдрийн дараа дахин амилсан гэдэгт итгэж байна. Та бол мөнхийн амьд Эзэн. Би таныг миний Эзэн гэж тунхаглаж байна. Би таныг миний Аврагч гэж тунхаглаж байна. Би танд амьдралаа өгч байна. Би таныг үлдсэн амьдралынхаа турш дагаж, үйлчлэх болно. Би одоо таных болсон. Би танд өөрийнхөө бүх сайн сайхан зүйл, бүх муу зүйлийг, бүх гэм нүглээ, бүх амьдралынхаа төлөвлөгөөг, бүх хүсэл мөрөөдлөө өгч байна. Таны хүсэл над дээр биелэх болтугай. Би зөвхөн сайн үйлсээр биш харин зөвхөн Танд итгэсэн учраас аварсан гэдэгт итгэж байна. Есүсийн нэр дээр залбирч байна. Амен.”**

### >>>> УРТ АЛГА ТАШИЛТ <<<<<

Бидний алга ташилт үнэхээр зохистой талархал байна. Библид хэлэхдээ нэг гэмтэн аврагдахад тэнгэрийн улс баярладаг гэж хэлсэн байдаг. Таны өнөөдөр хийсэн зүйлийг хараад тэнгэрийн улсад юу болдог тухай бидэнд зарим жишээнүүдийг өгсөн байдаг. Би та бүхэнд нэг зүйлийг хандан хэлэхийг хүсч байна, тэгээд би яриагаа дуусгах болно. Өнөөдөр энэ түүхийн гэрч болсон та нарыг нэгэн шийдвэрийг гаргаасай гэж хүсч байна. Биллийн энэ түүхийг сонссон бид үнэхээр аз завшаантай хүмүүс юм. Таныг энэ шийдвэрийг гаргахаасаа өмнө болгоомжтой хандахыг хүсч байна, хэрэв Ариун Сүнс таны амьдралд ажиллахыг зөвшөөрч байгаа бол энэ шийдвэрийг гаргахыг хүсч байна. Би энэ зүйлд хөнгөн хандахыг хүсэхгүй байна, миний хэлэх гээд байгаа гол санаа бол та энэ зүйлд үнэхээр нухацтай хандвал энэ шийдвэрийг гаргаасай гэж хүсч байна. Үүнд 2 зүйл байна. Нэгдүгээрт, би үүнээс хойш хүмүүсээс айхгүй. Яагаад гэвэл та одоо тэнгэрийн улс ба там гэж үнэхээр байдгийг мэдсэн. Би үүнээс хойш хүмүүсээс айхгүй. Хоёрдугаарт, би үлдсэн амьдралынхаа турш Есүсийн тухай, тэнгэрийн улс, тамын тухай хүн бүрт ярих болно. Энэ бол маш том шийдвэр. Есүсийг хүлээн авсан хүн бүр энэ хоёр шийдвэрт хүрдгийг би мэднэ. Хэн нэгэнд түүний сүнсийг тамаас аварсан гайхамшигт сайн мэдээг хуваалцахаас нааш харилцаатай байхын учир утга юу юм бэ? Та хэн нэгэнтэй харилцаатай байж, тэдэнтэй ярьж, хөөрч, хамт баярлан хөөрч, цагийг хамт өнгөрүүлдэг хирнээ тэдэнд Христгүй бол там уруу очино гэдгийг хэлэхгүй байх нь Сүнс доторх гэмт хэрэг. Таны өнөөдөр сонссон үнэн хүн болгонтой харилцах хаалганы нэвтрэх түлхүүр байх ёстой. Энэ бол бидний итгэлээс урган гардаг зүйл. Хэрэв та ийм зүйлд бэлэн биш байвал таныг би ойлгох болно. Харин та энэ 2 шийдвэрийг гаргахад надтай санал нэг байвал Бурханд хандан залбирахыг хүсч байна. **“Бурхан минь ээ, би танд итгэж байна. Таны Хүү Есүс Христ, Ариун Сүнсэнд итгэж байна. Би энэ цагт таны дуудлагыг хүлээн авахдаа бэлэн байна. Энэ бол миний шийдвэр гэж тунхаглаж байна. Би үүнээс хойш хүмүүсээс айхгүй. Хүн намайг юу гэж бодохоос би айхгүй. Миний талаарх бодол чухал биш. Би хүмүүсээс айх айдсыг үзэн ядах болно. Би үлдсэн амьдралынхаа турш хүн**

**бүрт Есүс Эзэн таны тухай, тэнгэрийн улс, тамын тухай ярих болно. Би хаалтыг даван гарах болно. Би үүнээс хойш хэвээрээ байхгүй, санаа зовомтгой, хайхрамжгүй байхгүй. Би Таны Үгийг хүлээн авч байна. Би айхгүйгээр ярих болно. Энэ бол Агуу Хүчит Бурханы өмнө гаргаж буй миний шийдвэр.”** Бурханы арми болсон та нар цаг үеийнхээ байдлыг мэдэрч чаддаг бүх дэлхий, улс үндэстэн, хот, хүмүүсийн дээр босогтун. Тэнгэрийн улсын сүр жавхлан ба тамын аймшгийг тодорхой харж, Бурханыг дагах шийдвэр гаргаж, өөрсдийн мөнхийн хувь заяаг шийдэх хүмүүсийн цаг ирж байна. Бид таны нигүүлслийг гуйн залбирч байна. Тэд өнөөдөр зоригтой шийдвэр гаргасан. Таны нигүүлсэлгүйгээр энэ зүйл биелэлээ олохгүй. Таны нигүүлсэл Бурханы бидэнд тушааж хэлсэн зүйлийг биелүүлэхэд хангалттай гэдэгт итгэж байна. Түүний хүмүүс болсон та нар дээр нигүүлсэл, нигүүлсэл, нигүүлсэл байх болтугай. Есүсийн нэр дээр залбирч байна.

[Amazon.com](http://Amazon.com)-оос түүний дэлгэрэнгүй гэрчлэл болох “Тамд өнгөрүүлсэн 23 минут” номыг худалдан авч болно.

[www.spiritlessons.com](http://www.spiritlessons.com)